



ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 1/11

Сайнцагаан сум

Зардал олгох тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Байгаль орчин, Ногоон Хөгжлийн Сайдын 2014 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А-82 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, судалгаа шинжилгээ, мониторинг, эргүүл, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэхээр байгаль хамгаалагчид сар бүр 30 литр шатахуун олгох хуваарыг хавсралтаар баталсугай.

2. Байгаль хамгаалагч нарт хяналт тавьж, тайлан мэдээг тогтмол авч ажиллахыг Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт, орчны бүс хариуцсан мэргэжилтэн /А.Цэцэгдэлгэр/-д үүрэг болгосугай.

3. Дээрх зардалд шаардагдах 398400 /Гурван зуун ерэн найман мянга дөрвөн зуун / төгрөгийг зардлыг ургамал хамгаалах сангаас сар бүр хуваарын дагуу олгож байхыг нягтлан бодогч /Б.Цэрэнмягмар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Р.БАТТУВШИН

ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
2018 ОНЫ 05 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДРИЙН А/11
ДУГААР ТУШААЛЫН ХАВСРАЛТ



№	Байгаль хамгаалагч нар	Сард олгох хэмжээ	Хэдэн удаа	Нийт
1	Д.Мөнх-Очир	10 литр	8 удаа	80 удаа
2	Т.Болдбаатар	10 литр	8 удаа	80 удаа
3	Х.Эрдэнэбат	10 литр	8 удаа	80 удаа